



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/109

Мандалговь

Зохион байгуулалтын арга хэмжээ  
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоол, 2017 оны 67 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн хэмжээнд газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийг 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр, гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийг 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрүүдэд тус тус зохион байгуулсугай.

2. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр, гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургуульд гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, байгууллага, алба хаагчид, иргэдийг идэвхтэй хамруулж ажиллахыг гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн удирдлага, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100259